



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/07.

Өвт

Хэсэгчилсэн хорио цээрийн дэглэм
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 59.1.21 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, 27¹ дүгээр зүйлийн 27¹.2, 27¹.3 дах хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5, 17 дугаар дугаар зүйлийн 17.2.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр малчин Т, Х нарын малд малын гоц халдварт шүлхий өвчин гарсан нь Улсын Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторын шинжилгээгээр батлагдсан тул 6 дугаар багийн нутаг дэвсгэрт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрөөс эхлэн 28 хоногийн хугацаагаар хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2. Хорио цээрийн дэглэм тогтоосон 6 дугаар багийн нутаг дэвсгэрт зайлшгүй шаардлагаар нэвтрэх хүн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс бусад шилжилт хөдөлгөөнийг бүрэн зогсоосугай.

3. Хорио цээрийн дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт ажиллах хөдөлгөөнт эргүүл, хяналтын пост, тандалт судалгааны баг, хяналтын багийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, хилийн заагийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Хорио цээрийн дэглэм сахиулах, голомтын бүсэд ажиллах хяналтын постод техник хэрэгсэл, хүн, хүч дайчлан гаргаж, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Онцгой комисс (Н.Бат-Эрдэнэ)-д, шаардагдах зардлыг Гамшгаас хамгаалах сан, Мал хамгаалах сангаас гаргахыг Санхүүгийн албаны дарга (О.Отгонтуяа) нарт даалгасугай..

5. Малын гоц халдварт шүлхий өвчин гадагш тархахаас хамгаалах, шүлхий өвчин халдварласан байж болзошгүй малд тандалт, үзлэг хийж, шүлхий өвчний голомтод ажиллан, ариутгал халдваргүйжүүлэлтийг бүрэн хийж ажиллахыг “Хустын рашаан” Мал эмнэлэгийн малын эмч (Л.Батчулуун)-д үүрэг болгосугай.

6. Зайлшгүй шаардлагаар Мал эмнэлгийн байгууллагын зөвшөөрлөөр нэвтрэх хүн, тээврийн хэрэгслийг халдваргүйтгэлд бүрэн хамруулахыг хяналтын постонд даалгасугай.

7. 6 дугаар багийн малчин иргэдийн байршлын зураглалыг гаргах, хүн, малын тооны судалгааг нарийвчлан гаргах, сэрэмжлүүлэг мэдээллийг өгч хорио цээрийн дэглэмийн журмыг чанд мөрдөн ажиллах талаарх иргэдийн гарын үсгийн баталгааг авч ажиллах, халдварт өвчний талаарх мэдээ мэдээллийг сумын цахим сүлжээгээр мэдээлж ажиллахыг Тандалтын багийн ахлагч тархвар зүйч (Р.Даваасүрэн), багийн Засаг дарга (Д.Дэмиддагва,) нарт, голомттой бүс нутгаас зорчихгүй байх, иргэдийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга (цагдаагийн ахмад Д.Энх-Амгалан), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

8. Голомтын бүсэд томилогдон ажиллаж байгаа албан хаагчид, голомтын бүсэд байгаа иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, өвчтөнийг хяналтанд авах, шаардлагатай эм, тарианы нөөцийг бүрдүүлэх, эрсдэлтэй бүлгийн судалгааг гаргаж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (Х.Цэдэндорж)-д даалгасугай.

9. 6 дугаар багийн нутаг дэвсгэр болон гадны хил залгаа аймаг, сумдаас амьд мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн, мах, сүү, цагаан идээг худалдах, худалдан авахыг тодорхойгүйгээр хугацаагаар хориглосугай.


10. Хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан иргэд, аж ахуйн нэгж, худалдаа эрхлэгч, байгууллагуудад үүрэг болгох нь:

а. Малын гоц халдварт шүлхий өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд нэн даруй сумын Шуурхай штабын утас 99323880 болон малын эмч, холбогдох мэргэжилтнүүдэд мэдээлэх.

б. Хорио цээрийн дэглэмийг чанд сахин, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг дагаж мөрдөх.

11. Хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан ерөнхий удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

3.

Сумын Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн А/07 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

**МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧИНЫ ҮЕД
АЖИЛЛАХ ХӨДӨЛГӨӨНТ ЭРГҮҮЛ, ПОСТ, ТАНДАЛТЫН БАГУУДЫН
ХУВААРЬ**

1. Хөдөлгөөнт ерөнхий эргүүл:

1. Н.Загарзүсэм (Цагдаагийн тасгийн Цагдаагийн ахлагч)
2. Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)
3. Ц.Нансандаваа (жолооч)

2. Газар нутгийн харъяалалын хөдөлгөөн эргүүл:

1. Хурцын ам Т.Эрдэнэ-Очир (малчин)
2. Хурцын их Ц.Баасанжав (малчин)
3. Шивэртий цох Ц.Галхүү (малчин)
4. Улиастайн дэнж Т.Эрдэнэбат (малчин)
5. Цагаан азарга Ц.Намжилдорж (БИНХ-ын тэргүүлэгч)
6. Горхин дэнж Жаргалсайхан (БИНХ-ын тэргүүлэгч)
7. Уурагт Ч.Гандармаа (БИНХ-ын тэргүүлэгч)
8. Бөөрөг Б.Авиддулам (БИНХ-ын дарга)
9. Гүүр, Шийрт, Бугат, Нарийн жалга Д.Дүгэрдорж (Байгаль хамгаалагч)

3. Голомтын бүсэд ажиллах баг:

1. Л.Батчулуун (Засаг даргын орлогч)
2. Б.Батбилэгт ("Хустын рашаан" Мал эмнэлгийн Малын эмч)

4.Тандалтын баг:

1. Р.Даваасүрэн (Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч)
2. Г.Сугар (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
3. Д.Очирхуяг (Ойн ангийн дарга)
4. П.Содномбалжир ("Хутагт уулын өгөөж" Мал эмнэлгийн Малын их эмч)
5. Г.Баярсайхан (жолооч)

5. 6 дугаар багийн иргэдийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих баг:

1. Н.Загарзүсэм (Цагдаагийн тасгийн Цагдаагийн ахлагч)
2. Х.Чулуунбат (ОХБЦГ-ын Хамгаалалтын захиргааны хэсгийн ахлагч)
3. М.Мөнхдалай (ОХБЦГ-ын Хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч)
4. Б.Авиддулам (БИНХ-ын дарга)

Сумын засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн А/07 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

ГОЛОМТЫН БҮС

Д/Д	Овог нэр	№ д	Огноо	Газрын нэр	Уртрага	өргөрөг	Урьдчилсан онош	Малын тоо				Өвчилсөн мал			
								Үхэр	хонь	ямаа	Бүгд	Үхэр	Хонь	Ямаа	
1	М.Хатанбаатар	6	2022.01.18	Хурц	46.772041	101.583939	Шүлхий	42	95	21					
2	М.Түмэнжаргал							45	80	90					

СЭЖИГТЭЙ БҮС

Д/Д	Овог нэр	Баг	Огноо	Газрын нэр	Уртрага	өргөрөг	Урьдчилсан онош	Малын тоо				Эрсдэл				
								Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Бага	Дунд	Маш өндөр		
1	Б.Мөнхбат							78	120	35	233					
2	С.Отгонсүрэн															
3	Т.Эрдэнэбат		2022.01.13	Ар бүрэгтий	46.422750	101.373323	Шүлхий	370	1320	50	1740					
4	Э.Гомбо							50	30		80					
5	Ц.Галхүү	6 дугаар баг						100	90	80	270					
6	Ц.Дэмбэрэл				46.665035	101.694506		150	200	150	500					
7	С.Батсүрэн			Өвөр	46.672153	101.672322		200	200	80	480					

8	Б. Батболд	2022.01.14	бүрэгтэй			Шүлхий	300	300	100	700		+
9	Д. Мөнхтогтох			46.670417	101.7046		60	150		210		+
10	Ц. Намжилдорж						40	200		420		+
11	Н. Хишигпүрэв						50	100	50	200		+
12	Цэвэлмаа	2022.01.14	Хүрдэт	46.704277	101.721172		100	70	40			+
13	Д. Ганзориг						160	200	200			+
14	Б. Батнасан						40					+

ХАМГААЛАЛТЫН БҮС

Д/д	Овог нэр	Баг	Огноо	Газрын нэр	Уртрага	өргөрөг	Урьдчилсан онош	Малын тоо				Эрсдэл			
								Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Бара	ДУНД	Маш өндөр	
1	С. Бүрэндаваа		2022.01.15	Хөх даваа				78	120	35		Бүгд			
4	Г. Ихбаяр		2022.01.14	Шавартын богч	46.722281	101.760855			25	35		70			
3	Ч. Найманжин		2022.01.14	Шаварт	46.732834	101.779603			40	200		120			
2	Н. Онотуул		2022.01.17	Уурагт	46.746457	101.838461		68	140			208			
5	П. Лувсандорж	6	2022.01.18	хүүш				78	120	35		233			
6	О. Хурцчулуун							15	35	85		135			
7	О. Цогтбаатар			Давааны өтөг	46.746	101.821145		15	25			40			

8	Ц.Батсүх		2022.01.14	Хүйтэн буудал	46.740024	101.7999		228	150	20	398		+
9	П.Батсүх		2022.01.18	Шийрт				65	280	220	367		+
10	Н.Мөнхтогтох							160			160		+
11	Л.Жаргалсайхан			Шийрт				250	100	100	350		+

--oOo--